



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

“МИК актив найм” ХХК-ийн гаргаж буй
хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг болон Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МИК актив найм” ХХК-ийн гаргаж буй 100,000 /нэг зуун мянган/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 20 хүртэл жилийн хугацаатай, нийт 1,898,404 /нэг сая найман зуун ерэн найман мянга дөрвөн зуун дөрөв/ ширхэг хүртэлх орон сууцны зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын хавсралтын дагуу бүртгэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/, төвлөрсөн хадгаламжид бүртгэж, холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэж ажиллахыг “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны танилцуулгад тусгасан 1,898,404 ширхэг хүртэлх баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын 1-д заасан нөхцлөөр үнэт цаас гаргагчид ирүүлсэн хөрөнгө оруулагчдын захиалгын гэрээний дагуу худалдахыг “МИК актив найм” ХХК-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “МИК актив найм” ХХК-д үүрэг болгосугай.

1/ Санхүүгийн зохицуулах хороо нь энэхүү тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэн нь тухайн үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багцад байгаа үл хөдлөх хөрөнгийн жагсаалтад байгаа мэдээлэл нь эрсдэлгүй, үнэн зөв гэсэн баталгаа биш бөгөөд хэрэв тухайн баталгаат үнэт цаасанд эрсдэл гарвал Санхүүгийн зохицуулах хороо хариуцахгүйг мэдэгдэхийн хамт энэ талаар үнэт цаасны танилцуулгад тусгайлан тэмдэглэж хөрөнгө оруулагчдад мэдээлэх;

2/ Энэ тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан уг үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн багц дахь үл хөдлөх хөрөнгийг Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн хамтарсан

000003

А/167/203 тоот тушаалаар батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийх бүртгэх тухай журам”-д заасны дагуу Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн байгууллага дахь барьцааны бүртгэлд бүртгүүлж, энэ талаар 4 сарын дотор Санхүүгийн зохицуулах хороонд эргэж мэдэгдэх;

3/ Баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг 30 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөр төлөх, мэдээллээр хангах болон бусад үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллах.

4. Баталгаат үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн багцад байгаа үл хөдлөх хөрөнгийг өөрийн компанийн нэр дээр урт хугацааны даатгалд даатгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “МИК ОССК” ХХК /Д.Гантөгс/-д үүрэг болгосугай.

5. Баталгаат үнэт цаасны борлуулалт, үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж, энэ талаар улирал бүр Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлж ажиллахыг “ҮЦТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д үүрэг болгосугай.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА